



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 02 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 02 дугаар хуралдаан 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр болов.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 02 дугаар хуралдаанаар /2025-02-03/ Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа сунгах, нэмэлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар шинээр олгох, сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Сүлжээний дугаарын ашиглалтад өөрчлөлт оруулах тухай үнэлгээ, дүгнэлт); ХХЗХ-ны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагад хасагдуулга хийх тухай; Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлангийн танилцуулга; Хорооны хуралдааны тэмдэглэл, протоколоор 2024 онд дарга, гишүүдээс гаргасан санал, өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэлийн хэрэгжилтийн танилцуулга зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 10 (Тогтоол №12-21, 2025-02-03) тогтоолыг батлан шийдвэрлэв.

ХХЗХ-ны ээлжит 02 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа сунгах, нэмэлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар шинээр олгох, сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Сүлжээний дугаарын ашиглалтад өөрчлөлт оруулах тухай үнэлгээ, дүгнэлт, холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 9 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 9 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 12 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 13 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Амар гранд ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 14 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 15 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Би Дабльюу Ай Эс ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) сунгасан;
- Шуудангийн тухай хуулийн 10.¹ дүгээр зүйлийн 10.¹.2 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 16 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд (Морин өртөө групп ХХК) нэмэлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 17 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Ойрад тв ХХК) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 18 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 2 хуулийн этгээдэд 2 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 19 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг (ЗГХЭГ) 2 жилээр сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 74 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 20 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын багцаас “780х-хххх” дугаарлалт бүхий нийт 100,000 /нэг зуун мянга/ дугаарыг буцаан авч, дугаарын ашиглалтад (Жимобайл нэт ХХК) өөрчлөлт оруулан тус тус шийдвэрлэв.

Тус хуралдаанаар ХХЗХ-ны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагад хасагдуулга хийх тухай танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, үндэслэл болон хавсралт жагсаалтын (Аудитын зөвлөмжийн дагуу хасагдуулах бага үнийн дүнтэй, насжилт өндөртэй авлагуудын дүн; Шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон дүн; Илүү төлөлтөөс нь шилжүүлэн тооцсон дүн; Програмын бодолтоос шалтгаалсан; Албан хүсэлт ирүүлсэн болон шүүхийн шийдвэртэй холбогдуулан тооцооны актаар баталгаажуулсан дүн; Бусад нөхцлөөр хасагдуулсан дүн) төслийг тус тус хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.10, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.4, Харилцаа холбооны зохицуулах хорооны “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 21 тоот тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэв. Энэхүү тогтоолын хавсралтаар ХХЗХ-ны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагад тохируулга хийх 89 /наян есөн/ тусгай зөвшөөрөл, эрхийн

бичиг, бүртгэлийн гэрчилгээний төлбөрийг гэрээний тусгай нөхцөл, илүү төлөлтийг өр төлбөртэй зөвшөөрлийн төлбөрт шилжүүлэн тооцох, программын бодолтоос шалтгаалж нэмэлт төлбөр тооцсоныг хасах, аудитын зөвлөмжийн дагуу бага үнийн дүнтэй, насжилт өндөртэй авлагуудыг данснаас хасах, тодорхойгүй орлогоос тодруулж хаах, шүүхийн шийдвэрээр хасагдуулах зэрэг шалтгаанаар нийт 419,207,866.39 /Дөрвөн зуун арван есөн сая хоёр зуун долоон мянга найман зуун жаран зургаан төгрөг гучин есөн мөнгө/-ийг данснаас хасаж, тайлагнахыг ЗУХАГ-т зөвшөөрөв. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгов.

ХХЗХ-ны ээлжит 02 дугаар хуралдаанаар Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, онцлох бүтээгдэхүүний танилцуулга; Хорооны хуралдааны тэмдэглэл, протоколоор 2024 онд дарга, гишүүдээс гаргасан санал, өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэлийн хэрэгжилтийн танилцуулгыг тус тус сонсов.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-02-06